

МЭРГЭШСЭН ХИЛЧИН ИНЖЕНЕР БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN FORMING THE TRAINING SYSTEM FOR TRAINING QUALIFIED BORDER ENGINEERS

Г.Ган-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Хил судлалын докторант, хурандаа

G.Gan-Erdene

Colonel, Ph.D. candidate in Border Studies, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: ganerdene@gmail.com

Хураангуй: Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт “Улсын хилийн халдашгүй дархан байдалд, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй ажиллагааг шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна (УИХ, Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2020).” гэж заасан нь Монгол Улсын хил хамгаалалтын процесс нь хүн төвтэй техник, технологийн аргад шилжиж байгааг харуулж байна. Иймд Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт, болон байгууллагын алба хаагчдын судалгаанд үндэслэн “Мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх тогтолцоо”-г боловсронгуй болгох талаар, санал дэвшүүлсэн.

Abstract: The Mongolian government's border policy document states that "Within the inviolability of the state border, security operations in the border area will be organized in a comprehensive manner based on scientific and technological achievements." This indicates that Mongolia's border security process is shifting to a more human-centered, technical and technological approach. Therefore, based on a study of the supply and demand for human resources in Mongolia's telecommunications and information technology sectors, as well as the organization's employees, a proposal was made to improve the "Training System for Qualified Border Engineers".

Түлхүүр үг: Мэргэшсэн хилчин инженер

Keyword: Qualified border engineer

Оршил:

Монгол Улсын хилийг хамгаалах асуудал нь үндэсний аюулгүй байдал, улсын тусгаар тогтнолыг баталгаажуулахад чухал ач холбогдолтой. Хилчдийн үүрэг бол зөвхөн хилийн харуулын үүрэг гүйцэтгэх төдийгүй, улс орны аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг хамгаалах өргөн хүрээтэй үүрэг хариуцлага байдаг. Энэ ч үүднээс хил хамгаалах байгууллага мэргэшсэн, чадварлаг хилчдийг бэлтгэх бодлогод онцгой анхаарч ирсэн. Орчин үед хил хамгаалалт нь хүн төвтэй техник, технологийн аргад шилжиж байгаа бөгөөд “Мэргэшсэн хилчин” гэдэг ойлголтод “Техник технологийн талаарх мэдлэг, чадварыг эзэмшсэн байх” гэдэг шинэ шалгуур, шаардлага нэмэгдэж байна. Үүнээс шалтгаалан холбоо, мэдээллийн

технологи, кибер аюулгүй байдал, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дохиолол хяналт, радио электрон тэмцлийн чиглэлээр мэргэшсэн алба хаагчдын хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энэ чиглэлээр мэргэжилтнүүдийг бэлтгэх, тэднийг тогтмол сургаж, хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Үндсэн хэсэг

“Хилчин” гэж хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг хэлнэ (Хилийн тухай хууль, 2016).

“Мэргэших” гэж нэг төрлийн шинжлэх ухааны дотроос аль нэг салбарыг нь дагнан судалж эзэмших (Монгол хэлний их тайлбар, 2025).

Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт “Улсын хилийн халдашгүй дархан байдалд,



Дотоод хэргийн их сургууль



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙН
БОЛОВСРОЛ СУДЛАЛ

хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй ажиллагааг шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна (УИХ, Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2020).” гэж заасан нь технологийн хөгжлийн эрин үед хилчдэд хил хамгаалах арга тактик, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварт улам өндөр түвшний шаардлагууд тавигдаж байгааг харуулж байна.

Орчин үеийн хил хамгаалах ажиллагаанд дрон, дохиолол хяналтын систем, мэдээллийн технологи төхөөрөмжүүд зэрэг шинэлэг дэвшилтэт технологиуд нэвтэрч байгаа тул хилчид эдгээр техник, технологийг эзэмших чадвартай байх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Мөн нэгэнт Улсын хил хамгаалалтын үйл ажиллагаа нь хүн төвтэй техникийн аргад шилжиж байгаа учир энэ чиглэлийн боловсон хүчнийг хэрхэн бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар авч үзэх нь зүйтэй.

Холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн эрэлт

Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас 2024 онд “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт”-ийн судалгаа хийхэд энэ чиглэлээр нийт 39 их дээд сургууль, 24 МСҮТ, политехник коллеж мэргэжилтэн бэлтгэж байсан бөгөөд нийт

төгсөгчид 100 хувь мэргэжлээрээ ажилд орно гэж тооцоолбол 2030 он хүртэл энэ чиглэлийн шинээр бий болох ажлын байрнуудын 30 орчим хувь нь мэргэжлийн хүний нөөцөөр хангагдаж чадахгүй гэж дүгнэлт гарсан байдаг. Энэ үзүүлэлт өнөөгийн байдлаар өсөлттэй байгаа нь тодорхой.

Технологийн дэвшил хурдацтай хөгжиж, холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт өндөр түвшинд хүрч байна. Монгол Улс ч мөн адил энэ хөгжилтэй хөл нийлүүлэн алхахын тулд дараах хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай:

-цахим шилжилт: Улс орнуудын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд цахим технологийг бүх салбарт нэвтрүүлэх хэрэгцээ үүсэж байна. Үүний тулд программист, системийн инженерүүд, мэдээллийн технологийн чиглэлээр чадварлаг мэргэжилтний эрэлт нэмэгдэж байна.

-инноваци: Их өгөгдөл, үүлэн технологи, хиймэл оюун, биет интернэт (IoT), зэрэг технологийн хэрэгцээ нэмэгдэж, эдгээр салбарт шинэ санал санаачилга, бизнесүүд төрөн гарч байна.

-мэдээллийн аюулгүй байдал: Кибер аюулгүй байдал нь орчин үеийн мэдээллийн технологийн хамгийн чухал чиглэл болсон тул энэ салбарт мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлага үүсэж байна.

Ажлын байр	Сарын дундаж цалин (MNT)	Хамгийн бага цалин (MNT)	Хамгийн өндөр цалин (MNT)
Программист	2,000,000 - 3,500,000	1,500,000	5,000,000
Системийн администратор	2,500,000 - 4,000,000	2,000,000	5,500,000
Мэдээллийн технологийн инженер	1,800,000 - 3,000,000	1,200,000	4,500,000
Кибер аюулгүй байдлын мэргэжилтэн	3,500,000 - 6,000,000	3,000,000	8,000,000
Холбооны инженер	1,500,000 - 2,500,000	1,000,000	3,500,000
Мэдээллийн технологийн зөвлөх	4,000,000 - 7,000,000	3,500,000	9,000,000
Мэдээллийн аюулгүй байдлын менежер	5,000,000 - 8,000,000	4,000,000	10,000,000

Хүснэгт 1. Монгол Улсад холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын салбарын ажилчдын цалингийн жишиг, үнэлэмж



Мэргэшсэн хүний нөөц бэлтгэх бодлого

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ (УИХ, “Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг, 2020)” зорилтын хүрээнд 2021- 2030 он хүртэл энэ салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

2.1.28. Мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ,

2.6.8. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтгүй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ,

7.5.5.Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ зэргээр бодлогын баримт бичгүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг тусгасан байна. Мөн Монгол Улсын Засгийн газар, боловсролын байгууллагууд, хувийн хэвшил хамтран холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх бодлогод дараах чиглэлүүдээр анхаарч байна:

-сургалт, дадлагын тогтолцоо: Технологийн салбарын хөгжлийг даган боловсролын тогтолцоонд цахим,

инновацийн лабораториуд байгуулах, суралцагчдад бодит дадлага дээр суралцах боломж олгох, ур чадварын сертификат олгох систем нэвтрүүлэх нь хүний нөөцийг мэргэшүүлэхэд чухал үүрэгтэй.

-төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа: Хувийн хэвшил, төрийн байгууллагууд хамтран ажиллаж, мэдлэгийг практик дээр мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг зохион байгуулах нь тустай. Мөн олон улсын техник технологийн томоохон компаниудтай хамтран ажиллах нь ч хүний нөөцийг хөгжүүлэх чухал алхам болно.

-боловсролын шинэчлэл: Энэ чиглэлээр их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын хөтөлбөрийг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох нь маш чухал болоод байна. Онолын мэдлэгээс гадна практик ур чадвар олгох сургалтуудыг түлхүү оруулах шаардлагатай.

Олон улсын туршлага

Дэлхий дахинд холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх хэд хэдэн амжилттай туршлага байна (Цахим хөгжил, 2021). Жишээлбэл:

-Финлянд улсын туршлага: Финляндын нь суралцагчдын бүтээлч ур чадварыг хөгжүүлэхийн тулд дадлагажих болон бодит төсөл дээр ажиллуулах аргын хэрэглэдэг. Энэ боловсролын арга нь шинжлэх ухаан, технологийн гүнзгий мэдлэг олгохыг зорьдог.

-Израил улсын туршлага: Тэдний боловсролын тогтолцоо, шинэ санаачилгыг дэмжих бодлоготой уялдсан байдаг. Мэдээллийн технологийн стартап экосистемийг хөгжүүлж, гарааны бизнесийн орчинд мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд анхаарч байна.

Хил хамгаалах байгууллагад энэ салбарын өнөөгийн нөхцөл байдал

Хил хамгаалах байгууллага нь холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр цэргийн удирдлагын тогтолцооны хүрээнд



ХҮҮЛЬ САХИУЛАХҮЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ

удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, стратегийн болон оператив түвшинд гадаад, дотоодод бэлтгэгдсэн ажлын тодорхой туршлага бүхий хүний нөөцтэй.

Сургалт бэлтгэлийг гадаад, дотоодын их сургуулиудад явуулахаас гадна өөрийн харьяаны Мэргэжлийн сургалтын төвийг түшиглэн зохион байгуулдаг.

	Бусад их, дээд сургуульд захиалгаар хүний нөөцөө бэлтгэх	Хилийн албаны сургуульд чиглэлийн тэнхим бий болгож мэргэжилтэн бэлтгэх	Чиглэлийн мэргэжлийн сургалтын төвтэй байснаар /Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн Мэргэжлийн сургалтын тасаг/
Давуу тал	Хүний нөөцийн илүүдэлд орохгүй	- Салбарын нарын мэргэжлийн чадварлаг эрдэмтэн, судлаачидтай болох; - Судалгаа шинжилгээний материаллаг бааз үүсэх; - Чадварлаг хүний нөөцийг ажлын байранд сонгон шалгаруулалтаар авах;	- Чиглэлийн алба хаагчдыг тасралтгүй мэргэшүүлэх, чадамжид суурилсан сургалтуудыг танимаар болон онлайнаар зохион байгуулах; - Мэргэшсэн багш, мэргэжилтэнтэй болох чиглэлийн судалгаа, шинжилгээний материаллаг бааз бүрдүүлэх
Сул тал	- Ажлын байрны шаардлага хангах алба хаагчдын эрэлт - Сургалтын төлбөр буюу санхүүжилтийн асуудал	Хүний нөөцийн илүүдэлд орох	Хүний нөөцийн илүүдэлд орох

Хүснэгт 2.Хил хамгаалах байгууллага холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх, мэргэжүүлэх боломж

Холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр ажил үйлчилгээ явуулдаг тасгуудад тулгарч буй хамгийн том бэрхшээл нь Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын мэдээллийн технологийн техник, хэрэгслийн ашиглалтын мэдлэг, чадвар дутмаг байгаагаас инженер, техникчдэд шаардлагагүй ажлын ачаалал ихээр үүсгэж, кибер аюулгүй байдлын заавар зөвлөмж өгсөөр байтал хэрэгжүүлж чадахгүй байгууллагын систем, сүлжээг эрсдэлд оруулдаг. Иймд ДХИС-ийн Хилийн албаны сургуульд мэргэжил эзэмшиж байгаа, мэргэших сургалтад хамрагдаж байгаа алба хаагчдад холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын сургалтыг зайлшгүй явуулж энэ чиглэлээр мэдлэг, чадвар эзэмшүүлэхгүй бол байгууллагын кибер аюулгүй байдал мөн хүний нөөцийн бодлогод сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Хил хамгаалах байгууллага холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх, мэргэжүүлэх туршлага, сургамж

Хил хамгаалах байгууллага нь 1937 оноос өнөөг хүртэл өөрийн нөөц бололцоогоор Мэргэжлийн сургалтын төвийг түшиглэн холбооны бага мэргэжилтэн бэлтгэж ирсэн бөгөөд Энэ сургалтын төгсөгчид нь зөвхөн Хил хамгаалах байгууллагад ажиллаад зогсохгүй Зэвсэгт хүчин, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллагуудын хүний нөөцийн шаардлага, шалгуурыг хангаж ажиллаж байгаа бөгөөд мэргэжлийн чадамж шаардсан тэмцээн уралдаануудад амжилт гарган оролцож байна. Мөн жил ирэх тусам энэ сургалтад суралцах хүсэлт гаргагчдын тоо өсөж байгаа нь бид энэ чиглэлийн сургалт явуулах туршлага, багшлах боловсон хүчин, бааз суурь бүрдүүлж чадсаныг харуулж байна.

Сургалт явуулах явцад зарим нэг сургамжууд гарч ирж байна. Үүнд:

-технологийн хөгжил хурдацтай байгаа тул сургалтын хөтөлбөрийг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, тогтмол шинэчилж байх;

-байгууллагын хэрэгцээнд тулгуурласан шинэ мэргэжлээр чадамжид суурилсан мэргэшүүлэх сургалтууд явуулах.

Мэргэшсэн хилчин инженер бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох

Угаас хомсдож байгаа мэргэжилтнийг Хил хамгаалах байгууллага тэр дундаа хилд үүрэг гүйцэтгүүлэхээр ажилд авахад хүндрэл тулгарна. Иймд бид холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөцийн бодлогоо ирээдүйд үүсэх эрсдэлтэй уялдуулж тохирох менежментийн дагуу төлөвлөх шаардлагатай байгаагаас гадна энэ төрлийн мэргэжилтнүүдийн хувьд технологийн хөгжлийн дагуу үргэлж шинэ зүйл сурч, хөгжих шаардлагатай бөгөөд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар нь тогтвортой өсөлттэй, карьерын өндөр боломжуудыг санал болгодог.

Мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх тогтолцоо гэдэг нь Хил хамгаалалтын үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшүүлэхийг зорьдог сургалтын цогц систем юм. Энэ тогтолцоо нь хилчин мэргэжлийн онцлог болон орчин үеийн технологи, инженерийн шаардлагад нийцсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чиглэнэ.

Хил хамгаалах байгууллагын мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх тогтолцоо:

1) Салбарын хүний нөөц бэлтгэж байгаа тэргүүлэх байгууллагуудад гэрээгээр мөн ДХИС-д инженерийн ерөнхий суурь мэдлэг, онол, практик ур чадвар эзэмшүүлж, мэргэжилтэн бэлтгэх;

2) Байгууллага өөрийн нөөц бололцоогоор хилчдийн ажлын онцлогт тулгуурлан мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх чадамжид суурилсан сургалт зохион байгуулж, техникч, холбоочин, оператор, бэлтгэх;

3) Салбарын хүний нөөц бэлтгэж байгаа тэргүүлэх байгууллагуудад мөн ДХИС, Мэргэжлийн сургалтын төвд инженер, техникч, холбоочин, операторыг мэргэшүүлэх;

4) Олон улсын магадлан итгэмжлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургуулиудад мэргэжил эзэмшүүлж, мэргэшүүлэх.

Хил хамгаалах байгууллагад дараах хэрэгцээ үүсэж байна. Үүнд:

- алба хаагчдын холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын техник хэрэгслийн ашиглалтын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх;

- холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөцийн дутагдлаас хамаарч өөр мэргэжлийн алба хаагчийг энэ салбарт хурдан, чанартай сургаж, ажиллуулах.

Иймд энэ хэрэгцээнд тулгуурлаж чадамжид суурилсан сургалтыг байгууллагын онцлогт тохируулж тогтмол зохион байгуулах шаардлагатай.



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ ХАМГААЛАХ
МОНГОЛЫН ИРГЭДНИЙ ХАМГААЛАХ
МОНГОЛЫН ИРГЭДНИЙ ХАМГААЛАХ

Чадамжид суурилсан сургалтын бүтэц





ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Мэргэшсэн хилчин инженерийг бэлтгэх чадамжид суурилсан сургалтын тогтолцоо нь суралцагчдыг тухайн мэргэжлийн тодорхой ур чадвар, мэдлэг, хандлагаар нь үнэлж, бодит амьдралд хэрэгжүүлэх боломжтой чадамжийг олгоход чиглэсэн сургалтын хэлбэр юм. Энэ тогтолцоо нь уламжлалт сургалтаас ялгаатайгаар үр дүнд суурилсан, суралцагчийн эзэмшсэн ур чадварыг тодорхойлох, тэднийг бодит амьдралд бэлэн болгоход анхаардаг. Харилцаа холбооны чиглэлээр чадамжид суурилсан сургалтын тогтолцоо нь орчин үеийн технологийн орчинд мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хамгийн тохиромжтой арга бөгөөд бодит ур чадварт суурилсан, үр дүнтэй, ажлын байранд бэлэн төгсөгчид бэлтгэдэг.

Мэргэшүүлэх сургалтын чанарыг үнэлэх үнэлэмжүүд нь сургалтын үр дүн, сургалтын хөтөлбөрийн бүтэц, багшийн чадвар, суралцагчдын оролцоо, дадлага, бодит амьдралд хэрхэн ашиглагдах зэргээс хамааран үнэлэгддэг.

Дүгнэлт, санал:

Угаасаа хомсдож байгаа мэргэжилтнийг Хил хамгаалах байгууллага тэр дундаа хилд үүрэг гүйцэтгүүлэхээр авахад хүндрэл тулгарна. Иймд бид холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөцийн бодлогоо ирээдүйд үүсэх эрсдэлтэй уялдуулж тохирох менежментийн дагуу төлөвлөх шаардлагатай нь харагдаж байна. Байгууллагын алба хаагчдаас авсан судалгааг дүгнэн Хил хамгаалах байгууллага энэ салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд дараах арга хэмжээг авах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

1. Байгууллага өөрийн нөөц бололцоогоор чиглэлийн хүний нөөцийг бэлтгэж, мэргэшүүлж чадварлаг

мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулж албандаа нэгтгэснээр ирээдүйн хөгжлийн түүчээ болно;

2. Мэргэжлийн сургалтын тасагт одоогоор зөвхөн радист ахлагч нарыг бэлтгэн, мэргэшүүлж байгаа бөгөөд цаашид хилд үүрэг гүйцэтгэж байгаа офицер болон ахлагч нарыг “Мэдээллийн технологи”, “Кибер аюулгүй байдал”, “Электроникийн засвар, үйлчилгээ”, “Дроны удирдлага, засвар”, “Радио релейн системийн ашиглалт, засварчин” мэргэжлүүдээр чадамжид суурилсан мэргэшүүлэх сургалтуудыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулснаар хүний нөөцийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй;

3. Одоогийн болон ирээдүйн ур чадварын хэрэгцээг тодорхойлох, ур чадварыг урьдчилан таамаглах системд хөрөнгө оруулалт хийж, ажиллах хүчний төлөвлөлтийг оновчтой тодорхойлох;

Ашигласан эх сурвалж, бүтээлийн жагсаалт:

тайлбар, М. х. (2025 оны 10 30). *Монгол хэлний их тайлбар*. Mongolitoli.mn-ээс Гаргасан
УИХ. (2016 оны 12 28). *Хилийн тухай хууль*. legalinfo.mn-ээс Гаргасан
УИХ. (2020). Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого: www.legalinfo.mn-ээс Гаргасан
УИХ. (2020 оны 05 13). *“Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг*. www.legalinfo.mn-ээс Гаргасан
УИХ. (2020). *Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого*. Засгийн газрын 2020 оны 20 дугаар тогтоол: www.legalinfo.mn-ээс Гаргасан
Цахим хөгжил, х. х. (2021). *Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа*. Улаанбаатар. google.mn: www.google.mn-ээс Гаргасан